

## САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

### НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2022 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан 2022 оны 6 сарын 17-ны өдрийн 1/15 дугаар удирдамжийн дагуу Булган аймгийн Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

### ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч А.Анхбаяр 2022 оны 9 сарын 19-ний өдрөөс хуанлийн 5 хоногт багтаан хяналт шалгалтыг хийв.

### ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Тус сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг автомашины замын хуудастай тулгаж, шатахууны хэтрэлт хэмнэлт, зарцуулалт, дотуур байр болон үдийн цай хөтөлбөрийн хүнсний бүтээгдэхүүн, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулав.

### ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Баян-Агт сумын Хүрэмт багт байрлах 9012893 регистрийн дугаартай Ерөнхий боловсролын сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд бага ангийн 10 бүлэгт 280 суралцагч, дунд ангийн 8 бүлэгт 211 суралцагч, ахлах ангийн 3 бүлэгт 58 суралцагч, нийт 21 бүлэгт 549 суралцагч, 34 багш, 22 туслах ажилтан 4 удирдах ажилтантайгаар сургалтын үйл ажиллагааг явуулж ирсэн байна. Тус сургууль нь .

2021-2022 оны хичээлийн жилд сурагчдын хоцрогдлыг арилгах, сурагчдын сурах таатай орчинг бүрдүүлж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх ажлын хүрээнд

- 1.Сурагч нэг бүрийн хоцрогдлыг оношлох, агуулгыг нөхөх,
- 2.Хичээлийн 35 минутыг маш чанартай үр дүнтэй зохион байгуулах,
- 3.Сурагчдыг ёс зүйтэй харилцааны соёлтой болгох,
- 4.Багш өөрийгөө болон гарын шавиа тасралтгүй хөгжүүлэх,
- 5.Уламжлалт ажлыг шинэлэг хэлбрээр чанартай зохион байгуулах,
- 6.Тогтоол шийдвэрүүдийг судлан ажиллах,
- 7.Дотоод хяналт, өмч хамгаалал, ёс зүй тандалтыг багийн үйл ажиллагааг тогтмолжуулах, гэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагааны 1 дүгээр гарын үсгийг 2021 оны 01 сарын 01-нээс 2021 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл Г.Пүрэвсүрэн, 2 дугаар гарын үсгийг 2021 оны 01 сарын 01-нээс 2021 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл Б.Оюун-Эрдэнэ нар зурсан ба төрийн санд бүртгэлийн 100040115101 тоот, нэмэлт санхүүжилтийн 100040115401 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэл болон няравын тайланг санхүүгийн тооцоолох “СТS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

Эд хариуцагчаар Ц.Сайнжаргал ажилласан байна.

#### ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Булган аймгийн Төрийн аудитын газраас хийсэн аудитын шалгалтаар зөрчилгүй санал дүгнэлт авсан. Аудитаар нийт 13.246,6 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрсэнээс 1.539,9 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 11.043,4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлаг хүргүүлж, 663,2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн байна.

#### ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Тус сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны касс харилцах, цалингийн баримт, захирлын тушаал, хүнс, бараа материалын баримт 2021 оны санхүүгийн тайлан, дотуур байрны суралцагчдын ирцийн бүртгэл, анги удирдсан багшийн журнал, жижүүр багшийн тэмдэглэл, хагас, бүтэн жилийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын баримт, хөдөлмөрийн дотоод журам зэрэг баримт материалуудад тулгуурлан захирал Г.Пүрэвсүрэн, нягтлан бодогч Б.Лхагвадулам, нярав Ц.Сайнжаргал нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

##### 6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

2021 онд улсын төсвөөс 950.598,3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 280.078,8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 1.608,5 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 1.225.417,7 мянган төгрөгийг зарцуулж, 14.581,8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Ажиллагсадтай холбоотой зардалд 736.610,1 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 94.427,7 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой тогтмол зардалд 278.501,5 мянган төгрөг, нормативт зардал 596,2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 5.969,9 мянган төгрөг, урсгал засвар 14.180,9 мянган төгрөг, томилолтын зардал 401,2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 9.187,1 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 7.189,4 мянган төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардалд 20.378,3 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулалд 550,0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 11364.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

## 6.2. Цалин урамшууллын талаар:

Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 3 сарын 30-ны өдрийн А/12 тоот тушаалаар багш ажилчдын 1-р улирлын үр дүнгийн урамшуулалд 14.355,4 мянган төгрөгийг, 6 сарын 24-ний өдрийн А/20 тоот тушаалаар багш ажилчдын 2-р улирлын үр дүнгийн урамшуулалд 14.774,8 мянган төгрөгийг, 9 сарын 24-ний өдрийн А/23 тоот тушаалаар багш ажилчдын 3-р улирлын үр дүнгийн урамшуулалд 11.791,5 мянган төгрөгийг, 12 сарын 14-ний өдрийн А/32 тоот тушаалаар багш ажилчдын 4-р улирлын үр дүнгийн урамшуулалд 21.622,7 мянган төгрөгийг, 9 сарын 24-ний өдрийн А/23 тоот тушаалаар багш нарт ур чадварын нэмэгдэл 1.488,2 мянган төгрөгийг, 10 сарын 22-ны өдрийн А/25 тоот тушаалаар Монголын багш нарын өдрийг тохиолдуулан П.Отгонтуяа, Б.Мягмарсүрэн нарт үндсэн цалингийн 80 хувиар тооцон 1.263,1 мянган төгрөг, Ж.Урантүлхүүр, Ш.Ариунаа нарт үндсэн цалингийн 30 хувиар тооцон 510,4 мянган төгрөгийг, 1 сарын 26-ны өдрийн А/05 тоот тушаалаар аймгийн хэмжээнд сургачдаас авсан шалгалтанд, ахиц амжилтаараа аймагт 1-3 дугаар байр эзэлсэн сурагчдыг бэлтгэсэн 6 багшид ур чадварын нэмэгдэл 884,6 мянган төгрөгийг 2 сарын 09-ний өдрийн А/06 тоот тушаалаар аймгийн хэмжээнд сургачдаас авсан шалгалтанд, ахиц амжилтаараа аймагт 1-3 дугаар байр эзэлсэн сурагчдыг бэлтгэсэн 4 багшид ур чадварын нэмэгдэл 863,3 мянган төгрөгийг, 3 сарын 30-ны өдрийн А/11 тоот тушаалаар багш нарын ур чадварын уралдаан, шилдэг нэгж хичээлийн хөтөлбөрт шалгарсан 5 багшид ур чадварын нэмэгдэл 747,6 мянган төгрөгийг, Баян-Агт сумын Засаг даргын 2021 оны 06 сарын 24-ний өдрийн Б/13 тоот захирамжаар ерөнхий боловсролын сургуулийн захиралд 1-р улирлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингаас 42 хувиар 405,2 мянган төгрөг, 2-р улирлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингаас 43 хувиар 414,9 мянган төгрөгийг, 06 сарын 21-ний өдрийн Б/11 тоот захирамжаар ерөнхий боловсролын сургуулийн захиралд хагас жилийн ур чадварын нэмэгдэл сар бүр 25 хувиар тооцон 1.206,1 мянган төгрөгийг, 09 сарын 27-ны өдрийн Б/16 тоот захирамжаар ерөнхий боловсролын сургуулийн захиралд 3-р улирлын үр дүнгийн урамшуулал үндсэн цалингийн 30 хувиар тооцон 289,4 мянган төгрөг, 09 сарын 27-ны өдрийн Б/17 тоот захирамжаар 3-р улирлын ур чадварын нэмэгдэл сар бүр 20 хувиар тооцон 578,9 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

Нэмэлт санхүүжилтийн талаар: 100040615401 тоот дансаар дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө 682,7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2.506,1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр Б.Нарангэрэлээс 133,1 мянган төгрөгөөр 10 метр хулдаас, Д.Ганзоригоос 550,0 мянган төгрөгөөр 1 ширхэг ширээ, 175,9 мянган төгрөгөөр 1 ширхэг сандал, Хануй Булган ХХК-иас 427,6 мянган төгрөгөөр 28 нэр төрлийн аж ахуйн материал, мөн 540,0 мянган төгрөгөөр угаалгын машин, Удган бэрх ХХК-иас 292,7 мянган төгрөгөөр бичиг хэргийн материал, Ж.Нэргүйгээс 300,0 мянган төгрөгөөр ХО06-003 маркын вакум насос, Сожид ХХК-иас 390,0 мянган төгрөгөөр ариутгал халдваргүйжилтийн материал, Баян хангайн агт ХХК-иас 259,5 мянган төгрөгөөр 13 нэр төрлийн 30 ширхэг аж ахуйн материал худалдан авсан байна.

## 6.3. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

№	Нэр	Мөнгөн дүн /мянган төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	1.528.011,9	0,00	138.142,6	1.389.869,3
2	Машин тоног төхөөрөмж	90.427,3	22.827,1	62.989,3	50.265,1
3	Тавилга, эд хогшил	97.359,6	27.720,4	49.654,0	75.426,1
4	Номын фонд	25.024,6	3.404,7		28.429,3
5	Биет бус хөрөнгө	39.530,0			39.530,0
6	Программ хангамж	1.750,0			1.750,0
	<b>Дүн</b>	<b>1.782.103,5</b>	<b>53.952,2</b>	<b>251.523,5</b>	<b>1.584.532,2</b>

2021 оны эхэнд 640416.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр Агтуу Хайрхан ХХК-иас нөүтбүүк 2 ширхэгийг 4.000,0 мянган төгрөгөөр, принтер 1 ширхэг 950,0 мянган төгрөгөөр, халуун тогоо 1 ширхэгийг 1.000,0 мянган төгрөгөөр, Хашхан ХХК-иас багшийн сандал 5 ширхэг 175,0 мянган төгрөгөөр, номын сангийн сандал 20 ширхэгийг 700,0 мянган төгрөгөөр, номын сангийн тавиур 5 ширхэгийг 1.550,0 мянган төгрөгөөр, самбар 5 ширхэгийг 1.275,0 мянган төгрөгөөр, дотуур байрны давхар ор 10 ширхэгийг 1,750.0 мянган төгрөгөөр, Евро-электроникс ХХК-иас дотуур байрны ширээ 5 ширхэгийг 499,3 мянган төгрөгөөр, дотуур байрны хувцасны шүүгээ 5 ширхэгийг 2.542,8 мянган төгрөгөөр, багш ширээ 5 ширхэгийг 1.160,0 мянган төгрөгөөр, бичиг хэргийн шүүгээ 10 ширхэгийг 3.441,6 мянган төгрөгөөр, хомын сангийн ширээ 10 ширхэгийг 1.029,4 мянган төгрөгөөр, Удган бэрх ХХК-иас ширээ 4 ширхэгийг 1.000,0 мянган төгрөгөөр, Нэкст эрдэнэт ХХК-иас DCP-T220 INKJET принтер 499,9 мянган төгрөгөөр, Бодь электроникс ХХК-иас суурин компьютер 1.625,8 мянган төгрөгөөр, хэвлэгч /канон/ 500,5 мянган төгрөгөөр, Ай Ти Зон ХХК-иас принтер 279,9 мянган төгрөгөөр, хувилагч 2.602,5 мянган төгрөгөөр, Нэкст дистрибьюшн ХХК-иас зурагт 2 ширхэгийг 986,7 мянган төгрөгөөр, угаалгын машин 2 ширхэгийг 965,8 мянган төгрөгөөр, хатаагч 839,9 мянган төгрөгөөр, Чиглэл ХХК-иас 2-р хоолны тогоо 3.916,0 мянган төгрөгөөр, 1-р хоолны тогоо 2.420,0 мянган төгрөгөөр худалдан авсан байна. ОНХ-ийн сангийн хөрөнгө оруулалтаар 990,0 мянган төгрөгийн сандал 15 ширхэг, 1.995,0 мянган төгрөгийн ширээ 15 ширхэг, 1.051,0 мянган төгрөгийн төмөр шкаф 2 ширхэг, 1.699,9 мянган төгрөгийн SSB-LED-FHOSO 321 1 ширхэг, БШУЯамнаас 1.900,0 мянган төгрөгийн теннисний ширээ 2 ширхэг, БШУЯамнаас 5.935,2 мянган төгрөгийн сурагч ширээ, сандал 126 ширхэг хөрөнгө хэмэгдсэн байна. Мөн өөрийн хөрөнгөөр 1.341,0 мянган төгрөгийн ном худалдан авч. Боловсрол соёл газраас номын санд 2.063,7 мянган төгрөгийн номыг шилжүүлэн авсанаар, жилийн эцэст 1.584.532,2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

#### 6.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /мянган төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Хүнсний материал	1.862,8	40.878,1	41.751,0	989,9
2	Аж ахуйн материал	81.459,4	24.049,7	15.305,0	90.204,1
3	Эм боох материал	240,3	1.477,3	1.542,6	175,0
4	Бичиг хэргийн материал	940,6	6.930,2	3.984,2	3.850,6
6	Түлш шатах тослох		2.014,6	2.014,6	
7	Бусад хангамжийн материал	1.292,5	20.378,3	21.335,7	335,1
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>85.759,7</b>	<b>95.728,4</b>	<b>85.933,3</b>	<b>95.554,8</b>

2021 оны эхэнд 85.759,7 мянган төгрөгийн бараа материал дээр төсвийн хөрөнгөөр 84.949,4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар БСШУЯамнаас хөнжил 40 ширхэг 1.600,0 мянган төгрөг, гудас 40 ширхэг 3.664,0 мянган төгрөг, хөл бөмбөг 5 ширхэг 395,0 мянган төгрөг, Боловсрол соёлын газраас /ковид-19/ ариутгалын багц 3 хайрцаг 371,2 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 3.758,8 мянган төгрөгийн 50 нэр төрлийн аж ахуйн материал, сумын онцгой комиссоос 990,0 мянган төгрөгийн 18 нэр төрлийн эм боох хэрэгсэл болон аж ахуйн материалыг авч, 85.933,3 мянган төгрөгийн бараа материал зарлагдаж, оны эцэст 95.554,8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

**6.5. Өглөг, авлагын талаар:**

Авлагын хувьд 2021 оны эхэнд бусад байгууллагаас авах авлага 15.742,5 мянган төгрөг байснаас цалингийн авлага 1.133,9 мянган төгрөг, хоолны авлага 1.503,5 мянган төгрөг, бусад зардлын тооцооны авлага 105,0 мянган төгрөг, нийт 2.742,5 мянган төгрөгийн авлагыг тайлант хугацаанд барагдуулж бусад байгууллагаас авах авлагын дүн 13.000,0 мянган төгрөг байна.

Өглөгийн хувьд 2021 оны эхэнд 685,9 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгтэй байсныг тайлант хугацаанд барагдуулан жилийн эцэст өглөггүй гарсан байна.

**6.6. Шилэн дансны талаар:** Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2021 онд төсөв, гүйцэтгэл цэсэнд 49 мэдээлэл оруулахаас, 47 мэдээллийг хугацаанд нь мэдээллэж 2 мэдээллийг хугацаа хоцроон, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын 39 мэдээллийг оруулахаас 37 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 2 мэдээллийг хугацаа хоцроон, бусад 61 мэдээлэл оруулахаас 57 мэдээллийг хугацаанд нь шивж, 4 мэдээллийг хугацаа хоцрон мэдээллэсэн байна.

**6.7. Тэтгэмж тусламжын талаар:** Сургуулийн захирлын 2021 оны 2 сарын 08-ний өдрийн Б/03 тоот тушаалаар ахмад багш Д.Цэвэлмаад түлээ худалдан авахад 140,0 мянган төгрөгийн тусламж, 5 сарын 31-ний өдрийн Б/10 тоот тушаалаар “Алдарт эх”-ийн 2 дугаар одон авсан Н.Даваадуламд 100,0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

**6.8. Дотуур байрны хүүхдийн хоолны махыг худалдан борлуулсан талаар:** Боловсролын сайдын 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/194 дугаар тушаал, БСУГ-ын даргын А/76 тоот чиглэлийг үндэслэн Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 5 сарын 25-ны өдрийн А/17 тоот тушаалаар сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны үлдэгдэл хөрөнгийг зарж борлуулан сургуулийн үндсэн дансанд тушаахаар шийдвэрлэсэн байна. Үүний дагуу 60,6 кг хонины махыг кг-ийг нь 8,0 мянган төгрөгөөр үнэлэн 485,0 мянган төгрөгөөр, 135,8 кг үхрийн махыг кг-ийг нь 7,5 мянган төгрөгөөр үнэлэн 1.018,5 мянган төгрөг нийт 1.503,5 мянган төгрөгөөр худалдан борлуулж, мах зарж борлуулсаны үнэ 1.133,9 мянган төгрөг 5 сарын 28-нд, Урнаагаас махны үнэ 181,6 мянган төгрөгийг 5 сарын 18-нд, Б. Отгонзулаас махны үнэ 188,0 мянган төгрөгийг 8 сарын 11-нд ЕБС-ийн 100040115101 тоот дансанд тушаасан байна.

**6.9. Дотуур байрны хүүхдийн хоолны зардалын талаар:** 2021 онд дотуур байрны хүүхдийн хоолны зардалыг нэг хүүхдэд ноогдох зардалыг 3475 төгрөгөөр тооцон 11582 хүүхдэд нийт 40.247,5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөн үдийн цай хөтөлбөрийн зардалд нэг хүүхдэд ноогдох зардлыг 900 төгрөгөөр тооцон 5173 хүүхдэд 4.655,7 мянган төгрөгийг, нэг хүүхдэд ноогдох зардлыг 1500 төгрөгөөр

тооцон 10690 хүүхдэд 16.035 мянган төгрөгийг, нийт 15863 хүүхдэд 20.690.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

6.10. Сургуулийн ойн хандивын талаар: Тус сургууль нь 1940 онд байгуулагдсан бөгөөд сургууль байгуулагдсаны 80 жилийн түүхт ойг 2020 оны 7-р сард тэмдэглэн өнгөрүүлэхээр санал гарган хамт олноороо хуралдан, сумын засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдэд хүсэлт явуулж зөвшөөрөл авсан байна.

Иргэдээс өгсөн хандивын орлогыг Ж. Сүхболд Э. Ням-Эрдэнэ нарын хамтын гарын үсгээр гардаг төрийн банкны 1201008557 тоот дансанд, төгсөгчид, аж ахуй нэгжээс өгсөн хандивыг Н. Өлзийбуян, Б. Оюунзул нарын хамтран эзэмшдэг 5271204725 тоот дансанд цуглуулсан байна. Иргэд, төгсөгчид, аж ахуйн нэгжээс нийт 65365000 төгрөгийг хандивласан байна. Мөн малчин иргэдээс хонь- 25, ямаа- 7- адуу-1 орсон адууг хүүхдийн хоолонд хэрэглэж хонь ямааг орон нутагт зарж үнийг өгсөн иргэдийн нэр дээр төрийн банкны дансанд хийсэн. Багуудын мөнгөн дүнг гаргахдаа малын үнийг оруулж тооцсон. Зарагдаагүй 2 хонь, 1-ямаа (Хэт жижиг). үлдсэн байна.

	<b>Баг</b>	<b>НИЙТ</b>
1	Шарга	15700000
2	Баянзүрх	4630000
3	Халтар	2500000
4	Хүрэмт	2800000
5	Баянхайрхан	10250000
6	Нэр нь тодорхой бус	460000
7	Төгсөгчдийн	7235000
8	Багш ажилчид	14790000
	Актив агро	7000000
	<b>НИЙТ</b>	<b>65365000</b>

Төрийн банкны 1201008557 тоот дансанд төвлөрсөн 44.373,5 мянган төгрөгийг зарцуулсан байдал.

№	Төрөл	Мөнгөн дүн
1	Гарын бэлэг	15428000
2	Хувцас, материал	1749000
3	Хөгжим хэрэгсэл	5350000
4	Сургуулийн үүдний тохжилт( Шкаф, шилэн самбар )	2350000
5	Монгол хэлний кабинетийн тохжилт	150000
6	Дотор засвар	2220000
7	Гадаа засвар	2264000
8	Ширээ сандал	4240000
9	Обой	560000
10	Паркетэн шал	1200000
11	Хөгжмийн багш	1400000
12	Хөшиг, чүүл	829000
13	Сандал, шкаф	512000
14	Бензин	1224000
15	Морины нөмрөг	2400000
16	Машины засвар	260000
17	Принтерийн хор	65000
18	Тээврийн хөлс	689500

19	Дотуур байрны хөшиг	1483000
	<b>Нийт</b>	<b>44373500</b>

Хаан банкны 5271204725 тоот дансанд төвлөрсөн мөнгийг зарцуулсан байдал

№	Төрөл	Мөнгө
1	Багш нарын дүрэмт хувцас	7950000
2	Ажилчдын дүрэмт хувцас	560000
3	Ус буцалгагч	1838000
4	Принтер	500000
5	Телевизор	5000000
6	Агаар чийгшүүлэгч	325000
7	Морины бэлэг	1681000
8	Наадмын талбай янзалсан	1027000
9	Төмөр хаалга	530900
10	Ангийн тохижилт	1130000
11	Улаанбаатар явсан бензин	402600
12	Притерийн хор	47000
	<b>Нийт</b>	<b>20991500</b>

2022 оны баяр наадмын 6 насны морийг иргэд өөрсдөө байлсан байна. Үүнд мотоцикл 6 ширхэг, бэлэн мөнгө 1.620,0 мянган төгрөг зарцуулсан (2 иргэнээс бусад нь дансанд төвлөрүүлж байгаад авч байлсан). Хандивын материалаас үндсэн хөрөнгөнд 10.662,0 мянган төгрөгний эд зүйл, аж ахуйн материалд 12.364,0 мянган төгрөгний хөрөнгө нийт 23.026,0 төгрөгний хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж авсан байна. Хандивын орлого, зарлагын тайланг хатм олны хурал болон иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнасан байна.

#### ДОЛОО. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Албан томилолтоор ажилласан албан хаагч нарт албан томилолтын зардлыг олгохдоо анхан шатны баримтын бүрдэл дутуу материалаар /томилолтын ирсэн, явсан хугацааг хаагаагүй/ бодож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/ заасныг;

2. Жилийн эцэст бусад байгууллагаас авах авлага 13,0 сая төгрөг байхад харилцагч байгууллагуудтайгаа тооцоо нийлсэн акт үйлдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6./эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заалтыг хэрэгжүүлээгүй;

3. Шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд 2021 онд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх зарчмыг баримтална/ заалт, 6 дугаар зүйлийн 6.1.2-т /.....сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор тогтмол мэдээлнэ./ заасан заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй;

#### НАЙМ. ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

Дотоод хяналт, өмч хамгаалал, ёс зүй тандалтын багийн үйл ажиллагааг тогтмолжуулах, гэсэн зорилт дэвшүүлэн сургалтын стандартыг хангуулах, хоол үйлдвэрлэлийн стандартыг хангах, орчны стандартыг хангах чиглэлээр дотоодын хяналт шалгалтыг хийсэн дэвшилттэй тал байгаа ч байгууллагын ил тод байдлын самбарт санхүүгийн тайлан мэдээ, төсвийн хуваарь, тухайн цаг үеийн шинэлэг зар мэдээг байршуулж хэвшээгүй байна.

**ЕС. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА,  
ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ**

Шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар 3 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

**ЕС. ДҮГНЭЛТ**

Байгууллагын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаанд дотоодын хяналт хийдэггүйгээс дээрх зөрчил дутагдал үүсч байна гэж дүгнэлээ.

**АРАВ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ**

1.Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам албан бичгээр ирүүлэх.

2.Дотоод хяналт зохион байгуулах журам боловсруулан дотоод хяналтыг оновчтой төлөвлөж, дотоод хяналтын чанар үр нөлөөг дээшлүүлэн илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар холбогдох албан тушаалтан, ажилтанд хугацаатай үүрэг чиглэл өгч, биелэлтийг тооцон, удирдлагад танилцуулан хариуцлага тооцох санал хүргүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах

3.Төсвийн хөрөнгөөр худалдан авсан эд хөрөнгийн үнийн мэдээлэл, урсгал засвар, баяр ёслолын үеэр зарцуулсан хөрөнгө зэрэг зардлын мэдээллийг ил тод байдлын самбарт мэдээлж байхын зэрэгцээ санхүүгийн тайланг аппаратын зөвлөгөөнд хагас бүтэн жилээр тайлагнаж байх

4.Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх;

5.Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулан 2022 оны 10 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанд албан бичгээр болон [sankhuu\\_audit\\_bu@yahoo.com](mailto:sankhuu_audit_bu@yahoo.com) хаягаар хариу ирүүлэх

**БИЧСЭН:**

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН  
БАЙЦААГЧ А.АНХБАЯР**

**ХЯНАСАН:**

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ  
ДАРГА САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Б.БАТТУЛГА**